

2025 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, Банкны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэг болон “Худалдаа, хөгжлийн банк” ХК (цаашид “Банк” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.16 дахь заалт болон 13 дугаар зүйлийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Банкны 2024 оны санхүүгийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсны дараах цэвэр ашгаас нийт хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсүгэй.
2. Банкны 2024 оны санхүүгийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсны дараа нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахтай холбоотой бусад асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА




РАНДОЛФ КОПША